



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 1/270

Номгон

Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг
ангилалтын ажлыг зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 9/58 дугаар “Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай” тогтоолын 90 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийж, баталгаажуулах,ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг 2026 оны 04 дүгээр сарын


20-ны өдрөөс 2026 оны 11 дүгээр сарын 15-ны хооронд технологит хугацаанд зохион байгуулсугай.

2.Үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэлт хийх малын тоо, зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх ажилд шаардагдах 10,000,000 (Арван сая) төгрөгийг Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

4.Тус ажлыг үр дүнтэй зохион байгуулж, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн санд хамруулж 2026 оны 11 дүгээр сарын 20-ны дотор тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Т.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхбаяр)-д даалгасугай.



626010733